



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 1/63

Улаанбаатар хот

Нийслэлийн ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2023 оны А/15 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 98,900,312.40 (ерэн найман сая есөн зуун мянга гурван зуун арван хоёр мянга дөчин мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 2 дугаар сургууль (Л.Цэнгэлмаа)-д зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй 30,693,200.4 (гучин сая зургаан зуун ерэн гурван мянга хоёр зуун төгрөг дөрвөн мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий зөөврийн компьютерыг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтанд дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгах, 68,207,112.0 (жаран найман сая хоёр зуун долоон мянга нэг зуун арван хоёр) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий зөөврийн компьютерыг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 1,800,000.0 (нэг сая найман зуу) төгрөгөөр худалдан борлуулж, орлогын 30 хувь болох 540,000.0 (таван зуун дөчин мянга) төгрөгийг нийслэлийн Өмчийн харилцааны газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд шилжүүлэхийг Нийслэлийн ерөнхий боловсролын 2 дугаар сургууль (Л.Цэнгэлмаа)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэст (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1150500261

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 04 дугаар сарын 22-ны өдрийн 163 дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн ерөнхий боловсролын 2-р сургууль

Д/д	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Бүгд үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	Байгууллагын үнийн санал	НӨХГ-ын мэргэжилтний дүгнэлт	ЭБХХХК-н шийдвэр
1	Багш зөврийн компьютер /леново/	9	ш	87	1,136,785.2	98,900,312.4	98,900,312.4	-	Дэлгэц гэмтсэн, плат шатсан, эх хавтан шатсан, CPU гэмтсэн, хатуу диск гэмтсэн, тэжээлийн блок сэнс шатсан, бусад эд анги гэмтэлтэй	Устгах	-	1,800,000	1,800,000
Машин тоног төхөөрөмж						98,900,312.4							
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн						98,900,312.4							
Үүнээс. Худалдах хөрөнгө						68,207,112							
Устгах хөрөнгө						30,693,200							

